



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/137/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Ахлах аудитор А.Даваадорж
Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn
Аудитор С.Алтанхуяг
Утас: 261628 Цахим хаяг: altankhuyags@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Албан шаардлага	16
4.3 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/399
танай _____-ны № _____-г

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Х.БАТЖАРГАЛ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үндэсний хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	716,743,080,788.66	991,438,404.59
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,324,841,701.04	-
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	14,324,841,701.04	-
31210	Төгрөг	14,324,841,701.04	-
31211	Төрийн сангийн харилцах	14,324,841,701.04	-
33	АВЛАГА	35,108,987.17	577,125,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	17,323,919.57	577,125,000.00
33500	Бусад авлага	17,785,067.60	-
33510	Байгууллагаас авах авлага	17,785,067.60	-
35	БАРАА МАТЕРИАЛ	392,909,577.09	395,113,404.59
35400	Хангамжийн материал	392,909,577.09	395,113,404.59
35410	Бичиг хэргийн материал	3,444,500.00	2,019,500.00
35420	Аж ахуйн материал	29,053,516.09	27,259,598.09
35440	Түлш, шатах тослох материал	1,840,261.00	3,000,006.50
35470	Бусад хангамжийн материал	358,571,300.00	362,834,300.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	701,990,220,523.36	19,200,000.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	701,990,220,523.36	19,200,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	205,723,310.29	392,862,758.01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	205,723,310.29	392,862,758.01
39200	Биет хөрөнгө	205,343,810.29	353,270,054.66
39203	Авто-тээврийн хэрэгсэл	50,850,000.00	56,362,330.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(40,349,999.98)	(14,030,194.11)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	373,747,939.28	568,132,369.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	(202,887,739.78)	(275,211,145.02)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	135,309,251.52	135,820,751.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	(111,744,640.75)	(118,223,057.01)
39217	Ном	419,000.00	419,000.00
39300	Биет бус хөрөнгө	379,500.00	39,592,703.35
39303	Бусад биет бус хөрөнгө	4,323,000.00	53,980,520.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(3,943,500.00)	(14,387,816.65)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	716,948,804,098.95	1,384,301,162.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	14,324,869,701.04	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,324,869,701.04	-
41300	Өглөг	14,324,869,701.04	-
41360	Бусад өглөг	14,324,869,701.04	-
41361	Байгууллагад төлөх өглөг	14,324,869,701.04	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	702,623,934,397.91	1,384,301,162.60
51	Засгийн газрын хувь оролцоо	702,623,934,397.91	1,384,301,162.60
51200	Хуримтлагдсан үр дүн	702,601,084,397.91	1,361,451,162.60
51210	Өмнөх үеийн үр дүн	482,552,660,540.73	702,601,084,397.91
51220	Тайлант үеийн үр дүн	220,048,423,857.18	(701,239,633,235.31)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	22,850,000.00	22,850,000.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	716,948,804,098.95	1,384,301,162.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	333,066,695,035.38	2,270,074,834.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,734,167,405.38	266,043,780.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,734,167,405.38	266,043,780.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,734,167,405.38	266,043,780.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,719,707,405.38	250,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	460,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	14,000,000.00	265,793,780.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	322,332,527,630.00	2,004,031,054.75
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	322,332,527,630.00	1,341,483,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,359,435,400.00	1,341,483,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	320,973,092,230.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	662,548,054.75
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	662,548,054.75
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	113,018,271,178.20	703,509,708,070.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	113,018,271,178.20	703,509,708,070.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	104,134,950,916.20	703,465,931,121.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	735,377,829.00	726,967,491.51
210101	Үндсэн цалин	533,120,129.84	527,081,839.50
210102	Нэмэгдэл	152,716,299.16	119,649,674.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,541,400.00	80,235,977.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,859,877.00	97,226,032.59
210201	Тэтгэврийн даатгал	69,705,477.00	67,843,531.21
210202	Тэтгэмжийн даатгал	7,288,600.00	7,552,909.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,830,900.00	5,877,567.76
210204	Ажилгүйдлийн даатгал	1,457,600.00	1,450,292.94
210205	Эрүүл мэндийн даатгал	14,577,300.00	14,501,731.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,240,650.00	55,034,300.00
210301	Гэрэл, цахилгаан	33,136,583.00	26,495,600.00
210302	Түлш, халаалт	25,427,683.00	19,557,500.00
210303	Цэвэр, бохир ус	13,676,384.00	8,981,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	73,649,998.40	98,709,779.34
210401	Бичиг хэрэг	12,085,110.00	23,457,649.00
210402	Тээвэр, шатахуун	20,858,691.00	25,770,312.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,558,047.40	31,426,637.84
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,148,150.00	18,055,180.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,186,200.00	8,556,640.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,983,200.00	3,110,540.00
210604	Урсгал засвар	203,000.00	5,446,100.00
2107	Томилолт, зочны зардал	10,763,686.73	11,908,200.00
210701	Гадаад албан томилолт	3,119,011.73	-
210702	Дотоод албан томилолт	6,786,000.00	11,312,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	858,675.00	596,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,485,688,991.50	321,894,154.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,481,565,870.50	277,874,157.00
210803	Даатгалын үйлчилгээ	281,100.00	631,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	92,100.00	69,752.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,325,421.00	42,104,125.55

**Үндэсний хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	424,500.00	1,214,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96,647,183,683.57	702,145,634,523.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	96,590,910,147.52	702,045,858,191.36
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	56,273,536.05	99,776,332.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,883,320,262.00	43,776,948.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,060,247.10	6,800,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,693,647.10	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,366,600.00	6,800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,745,041.30	36,976,948.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,745,040.90	19,683,371.32
213304	Хөрөнгийн	0.4	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	17,293,577.11
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,817,514,973.60	-
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	8,817,514,973.60	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	220,048,423,857.18	(701,239,633,235.31)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	220,048,423,857.18	(701,239,633,235.31)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	482,344,267,840.73	482,344,267,840.73
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	482,344,267,840.73	482,344,267,840.73
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	22,850,000.00	-	22,850,000.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	208,392,700.00	208,392,700.00
9	Тайлант үеийн үр дүн	-	-	220,048,423,857.18	220,048,423,857.18
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	22,850,000.00	702,601,084,397.91	702,623,934,397.91
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	22,850,000.00	702,601,084,397.91	702,623,934,397.91
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	22,850,000.00	702,601,084,397.91	702,623,934,397.91
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(701,239,633,235.31)	(701,239,633,235.31)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	22,850,000.00	1,361,451,162.60	1,384,301,162.60

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	359,785,714,981.14	2,021,604,974.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	37,298,352,532.14	250,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	37,298,352,532.14	250,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	37,298,352,532.14	250,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,719,707,405.38	250,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	460,000.00	-
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	26,578,185,126.76	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	322,487,362,449.00	2,021,354,974.32
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	322,332,527,630.00	1,341,483,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,359,435,400.00	1,341,483,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	320,973,092,230.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	154,834,819.00	679,871,974.32
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	154,834,819.00	679,871,974.32
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,481,381,250.50	16,325,687,675.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	24,481,381,250.50	16,325,687,675.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,794,496,627.93	1,379,944,025.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	732,571,915.00	726,967,491.51
210101	Үндсэн цалин	530,314,215.84	527,081,839.50
210102	Нэмэгдэл	152,716,299.16	119,649,674.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,541,400.00	80,235,977.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,859,877.00	97,226,032.59
210201	Тэтгэврийн даатгал	69,705,477.00	67,843,531.21
210202	Тэтгэмжийн даатгал	7,288,600.00	7,552,909.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,830,900.00	5,877,567.76
210204	Ажилгүйдлийн даатгал	1,457,600.00	1,450,292.94
210205	Эрүүл мэндийн даатгал	14,577,300.00	14,501,731.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,149,100.00	52,995,900.00
210301	Гэрэл, цахилгаан	29,439,400.00	25,514,200.00
210302	Түлш, халаалт	21,730,500.00	18,833,100.00
210303	Цэвэр, бохир ус	9,979,200.00	8,648,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	68,319,417.00	90,942,715.24
210401	Бичиг хэрэг	9,375,650.00	21,463,400.00
210402	Тээвэр, шатахуун	9,938,267.00	25,814,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,660,400.00	25,848,285.24
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,345,100.00	17,816,130.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,243,200.00	15,086,410.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,040,200.00	9,640,310.00
210604	Урсгал засвар	203,000.00	5,446,100.00
2107	Томиллолт, зочны зардал	10,623,311.73	11,897,600.00
210701	Гадаад албан томиллолт	3,119,011.73	-
210702	Дотоод албан томиллолт	6,786,000.00	11,312,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	718,300.00	585,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,645,025,837.50	302,921,997.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,640,770,716.50	257,531,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	281,100.00	631,920.00

Үндэсний хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	92,100.00	69,752.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,325,421.00	43,475,125.55
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	556,500.00	1,214,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	166,703,969.70	81,905,879.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	166,703,969.70	81,905,879.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,686,884,622.57	14,945,743,649.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,060,247.10	6,800,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,693,647.10	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,366,600.00	6,800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	54,068,960.87	614,101,948.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,745,040.90	17,293,574.11
213304	Хөрөнгийн	0.40	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	17,323,919.57	596,808,374.32
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,603,755,414.60	14,324,841,701.04
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	13,603,755,414.60	14,324,841,701.04
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	335,304,333,730.64	(14,304,082,701.04)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	320,979,492,029.60	20,759,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	320,979,492,029.60	20,759,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	320,979,492,029.60	20,759,000.00
220001	Барилга байгууламж	320,973,092,229.60	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,399,800.00	20,759,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(320,979,492,029.60)	(20,759,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	14,324,841,701.04	(14,324,841,701.04)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	14,324,841,701.04
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,324,841,701.04	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,402,002,400.00	1,324,439,425.89	77,562,974.11	94.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,402,002,400.00	1,324,439,425.89	77,562,974.11	94.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,345,785,800.00	1,317,639,425.89	28,146,374.11	97.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	728,865,700.00	726,967,491.51	1,898,208.49	99.74
210101	Үндсэн цалин	563,301,600.00	527,081,839.50	36,219,760.50	93.57
210102	Нэмэгдэл	120,283,500.00	119,649,674.14	633,825.86	99.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,280,600.00	80,235,977.87	(34,955,377.87)	177.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,396,800.00	97,226,032.59	1,170,767.41	98.81
210201	Тэтгэврийн даатгал	69,242,200.00	67,843,531.21	1,398,668.79	97.98
210202	Тэтгэмжийн даатгал	7,288,700.00	7,552,909.51	(264,209.51)	103.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,830,900.00	5,877,567.76	(46,667.76)	100.80
210204	Ажилгүйдлийн даатгал	1,457,700.00	1,450,292.94	7,407.06	99.49
210205	Эрүүл мэндийн даатгал	14,577,300.00	14,501,731.17	75,568.83	99.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,995,900.00	52,995,900.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	25,514,200.00	25,514,200.00	-	100.00
210302	Түлш, халаалт	18,833,100.00	18,833,100.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	8,648,600.00	8,648,600.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	85,255,100.00	85,253,215.24	1,884.76	100.00
210401	Бичиг хэрэг	15,773,900.00	15,773,900.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	25,814,900.00	25,814,900.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,848,300.00	25,848,285.24	14.76	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,818,000.00	17,816,130.00	1,870.00	99.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,887,000.00	22,885,410.00	1,590.00	99.99
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,440,000.00	17,439,310.00	690.00	100.00
210604	Урсгал засвар	5,447,000.00	5,446,100.00	900.00	99.98
2107	Томиллолт, зочны зардал	595,400.00	585,600.00	9,800.00	98.35
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	595,400.00	585,600.00	9,800.00	98.35
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	264,192,600.00	251,100,997.55	13,091,602.45	95.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	218,430,800.00	205,710,000.00	12,720,800.00	94.18
210803	Даатгалын үйлчилгээ	836,200.00	631,920.00	204,280.00	75.57
210804	Тээврийн хэрэгслийн татвар	222,900.00	69,752.00	153,148.00	31.29
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	12,200.00	-	12,200.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	43,476,300.00	43,475,125.55	1,174.45	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,214,200.00	1,214,200.00	-	100.00

Үндэсний хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,597,300.00	80,624,779.00	11,972,521.00	87.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	92,597,300.00	80,624,779.00	11,972,521.00	87.07
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,216,600.00	6,800,000.00	49,416,600.00	12.10
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	7,500,000.00	-	7,500,000.00	0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	7,500,000.00	-	7,500,000.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,716,600.00	6,800,000.00	41,916,600.00	13.96
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	41,770,000.00	-	41,770,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,946,600.00	6,800,000.00	146,600.00	97.89
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,402,002,400.00	1,324,439,425.89	77,562,974.11	94.47
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,402,002,400.00	1,324,439,425.89	77,562,974.11	94.47
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,402,002,400.00	1,324,439,425.89	77,562,974.11	94.47
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
610001	Төсвийн байгууллага	1	1	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	55	55	-	
620001	Удирдах ажилтан	2	2	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	50	50	-	
620003	Үйлчлэх ажилтан	3	3	-	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	55	55	-	
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	52	52	-	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3	3	-	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Үндэсний хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайлангаар шалгагдагч байгууллагад анхан шатны баримтыг бүрдүүлэх, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 21-ний хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор С.Алтанхуяг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Гүнжидмаа хэрэгжүүлсэн.

Үндэсний хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 03/24 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Үндэсний хөгжлийн газар нь эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, хөгжлийн бодлогыг хүн амын нутагшилт, суурьшил, бүсчилсэн хөгжлийн болон орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хөрөнгө оруулалтын нэгдсэн болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг зохистой төлөвлөж улсын эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх эрхэм зорилготой Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Үндэсний хөгжлийн газар нь дотоод хяналтын нэгжтэй боловч дотоод хяналт хангалтгүй, удирдлагын хяналт сул буюу төсөв захирагч нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*”, ерөнхий нягтлан бодогч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн

бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасан хяналтын үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Үндэсний хөгжлийн газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүү байдлын тайлангийн нийт хөрөнгө 1,403,932.04 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 28,078.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 21,058.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Үндэсний хөгжлийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 715,564,502.9 мянган төгрөгөөр буюу 99.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	14,324,841.7	-	(14,324,841.7)
Авлага	35,109.0	577,125.0	542,016.0
Бараа материал	392,909.6	395,113.4	2,203.8
Бусад эргэлтийн хөрөнгө	701,990,220.5	19,200.0	(701,971,020.5)
Үндсэн хөрөнгө	205,723.3	392,862.8	187,139.5
Нийт хөрөнгө	716,948,804.1	1,384,301.2	(715,564,502.9)
Өр төлбөр	14,324,869.7	-	(14,324,869.7)
Засгийн газрын хувь оролцоо	702,623,934.4	1,384,301.2	(701,239,633.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	716,948,804.1	1,384,301.2	(715,564,502.9)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Монгол улсын засгийн газрын тухай хуулийн 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд байсныг Шадар сайдын эрхлэх асуудал болгож өөрчилсөнтэй холбоотойгоор оны эхний мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн дансанд байршиж байсан техник хяналт, барьцааны 14,324,841.7 мянган төгрөгийн үлдэгдлийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн;
- Хэрэгжиж дуусаагүй төсөл хөтөлбөрийн үлдэгдэл санхүүжилтийг Сангийн яамтай 577,125.0 мянган төгрөгөөр тооцоо нийлж татаас, санхүүжилтийн авлагаар бүртгэсэн нь авлагын өсөлтөд нөлөөлсөн;
- Бүтцийн өөрчлөлтөөр оны эхний хэрэгжиж дуусаагүй төсөл, хөтөлбөрийн санхүүжилт 701,971,020.5 мянган төгрөгийн үлдэгдлийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт бараа ажил үйлчилгээний зардлын ангиллаас шилжүүлснээр бусад эргэлтийн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данс буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус газар нь 2021 оны урсгал санхүүжилтийн эх үүсвэрийг 557,138,421.4 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 7,787,131.4 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 549,351,290.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сангийн яамнаас Монгол улсын засгийн газрын тухай хуулийн 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд байсныг Шадар сайдын эрхлэх асуудал болгож өөрчилсөнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалтын зардлыг Төрийн худалдан авах ажиллагааны газар шилжүүлж, урсгал санхүүжилтийг 1,482,065.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээнд 1,402,002.4 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 1,324,439.4 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, 94.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70201	Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт	1,402,002.4	1,324,439.5	77,562.9	94.5
1.1	80101	Үйл ажиллагааны урсгал зардал	1,123,468.0	1,071,744.7	51,723.3	95.4
1.2	80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	15,481.4	14,210.0	1,271.4	91.8
1.3	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	117,600.0	117,600.0	0.0	100.0
1.4	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	68,008.0	59,800.0	8,208.0	87.9
1.5	80218	Улс орноо гадаадад сурталчлах	17,341.4	14,100.0	3,241.4	81.3
1.6	81520	Олон улсын хурал, зөвлөгөөн з/б зардал	53,157.0	40,184.8	12,972.2	75.6
1.7	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	6,946.6	6,800.0	146.6	97.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол улсын засгийн газрын бүтцийн тухай хуулийн 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр Эдийн засаг, хөгжлийн яамыг шинээр байгуулж, Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 14 дүгээр “Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг-Үндэсний хөгжлийн газрыг татан буулгасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Монгол улсын засгийн газрын тухай хуулийн 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд байсныг Шадар сайдын эрхлэх асуудал болгож өөрчилсөн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Үндэсний хөгжлийн газар 2021 онд нийт 1,774,441.9 мянган төгрөгийн 55 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 832,763.4 мянган төгрөгийн 20 мэдээллийг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх талаар албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмжийн хэрэгжилтийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 100.0 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	3,110,149.1	2	3,110,149.1	-	-	100.0
Албан шаардлага	1		1				100.0
Зөвлөмж	2	17,785.1	2	17,785.1	-	-	100.0
Нийт дүн	5	3,127,934.2	5	3,127,934.2		-	100.0

Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн актын дагуу Алтай-Дарви чиглэлийн 98 км, 165 км хатуу хучилттай авто зам төслийн техник хяналтын зардлаас хэмнэгдсэн 3,039,347.9 мянган төгрөгийн, Чойр дэд станцын өргөтгөл, шинэчлэлт төсөл, Мандал сум, Зүүн хараа чиглэлийн 15.8 км хатуу хучилттай авто зам төслүүдийн техник хяналтын зардлаас хэмнэгдсэн 70,801.2 төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 40,635.1 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 19,630.9 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 12,517.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгч, 8,487.1 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 4 алдаа, зөрчлийн дүн 21,004.2 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 28,078.6 мянган төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар татаас, санхүүжилтийн авлагын үлдэгдлийг 19,630.9 мянган төгрөгөөр илүү илэрхийлснийг залруулав.

4.2 Албан шаардлага

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлээгүй, томилолтын болон бичиг хэрэг зардлыг батлагдсан төсвөөс 12,517.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.5 болон 1.9 заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 10.1.7, 10.1.11-д заасныг тус тус үндэслэн төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төрөөс гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөх.

2. Тус байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материалын орлого, зарлагад ерөнхий нягтлан бодогч хяналт хэрэгжүүлж хэвшээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах талаар албан шаардлага өгөх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу 3,245.0 мянган төгрөгийн бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтаар баталгаажсан гүйлгээг данс бүртгэлд тусгах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Илрүүлэлт:

Цалингийн зардлыг Нийгмийн даатгалын тайлан, ХХОАТ-ын тайлан болон санхүү үр дүнгийн тайланд 5,242.1 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2. Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг дахин шалгаж, Нийгмийн даатгалын хэлтэс болон харьяа татварын газартай тооцоо нийлж, холбогдох засварыг хийх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар														
1	Үндэсний хөгжлийн газар	АХГ-2022/137/НА-СТА-ТШЗ	Татаас, санхүүжилтийн авлага дансыг 19,630.9 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн	Залруулга хийв	1	19,630.9	1	19,630.9						
2	Үндэсний хөгжлийн газар	АХГ-2022/137/НА-СТА-ТШЗ	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлээгүй, томилолтын болон бичиг хэрэг зардлыг батлагдсан төсвөөс 12,517.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна	Төсвийн тухай хуулийн 10.1.7, 10.1.11-д заасныг тус тус үндэслэн төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төрөөс гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах	1	12,517.1					1	12,517.1		
3	Үндэсний хөгжлийн газар	АХГ-2022/137/НА-СТА-ТШЗ	Анхан шатны баримтын бүрдэл дутуу зардал гаргасан.	Анхан шатны баримтаар баталгаажсан гүйлгээг данс бүртгэлд тусгах, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	3,245.0							1	3,245.0
4	Үндэсний хөгжлийн газар	АХГ-2022/137/НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгө, бараа материалын орлого, зардалд ерөнхий нягтлан бодогч хяналт хэрэгжүүлж хэвшээгүй.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах	1	-					1	-		
5	Үндэсний хөгжлийн газар	АХГ-2022/137/НА-СТА-ТШЗ	Цалингийн зардлыг Нийгмийн даатгалын тайлан, ХХОАТ-ын тайлан, СҮДТ-нд зөрүүтэй тайлагнасан байна.	Байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг дахин шалгаж, Нийгмийн даатгалын хэлтэс болон харьяа татварын газартай тооцоо нийлж, холбогдох засварыг хийх	1	5,242.1							1	5,242.1
Дүн					5	40,635.1	1	19,630.9			2	12,517.1	2	8,487.1

Үндэсний хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал														
1	Үндэсний хөгжлийн газар	АХГ-2022/137/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна	Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах	1	832,763.4					1	832,763.4		
Дүн					1	832,763.4					1	832,763.4		
Нийт дүн					6	873,398.5	1	19,630.9			3	845,280.5	2	8,487.1



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 93/А0160056

Улаанбаатар хот

АХГ - 2022/1371/НА-СТА-ТМБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Үндэсний хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 2021 оны 43 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлээгүй, томилолтын болон бичиг хэргийн зардлыг баталсан төсвөөс 12,517,052.3 төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх", 1.9 "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулах, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, үргүй зардал гаргахгүй байхад анхаарч, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эдийн засаг хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, нягтлан бодогч С.Давааням нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

(Handwritten signatures and stamps)

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
А.ДАВААДОРЖ
С.АЛТАНХУЯГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойрог, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherag\Alban_Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-82.Docx

9019120396

0010800272



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 74/А0160056

Улаанбаатар хот

АХГ-2022/137/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Үндэсний хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материалын орлого, зарлагад ерөнхий нягтлан бодогч хяналт хэрэгжүүлж хэвшээгүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулж байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, нягтлан бодогч С.Давааням нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
А.ДАВААДОРЖ
С.АЛТАНХУЯГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 75/АД160056
АХГ-2022/137/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Үндэсний хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 832,763,400.00 төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалтыг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй байхад анхаарч, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, нягтлан бодогч С.Давааням нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

[Handwritten signature]

Ц НАРАНЧИМЭГ
Г ГҮНЖИДМАА
А ДАВААДОРЖ
С АЛТАНХУЯГ

